

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБАНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 01 сарын 04 өдөр

Дугаар 1/04

Чөдөр

Г Хэвлэмэл хуудасны индекс батлах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, Архивын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.1, Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан "Тамга тэмдэг, баталгааны тэмдэг хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх заавар"-ын 38, Архивын ерөнхий газрын даргын 2016 оны А/142 дугаар тушаалаар батлагдсан "Хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх, хадгалах журам"-ын 4.4, 4.5-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Санхүүгийн хяналт, аудитын албанд хэрэглэх хэвлэмэл хуудасны нэр төрөл, тэдгээрийн индексийг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тушаалыг 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн дагаж мөрдүүлж хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажиллахыг архив, бичиг хэргийн ажилтан /Э.Цэлмэгбаяр/-г үүрэг болгосугай.

ДАРГА



Н.АЛТАНЦЭЦЭГ

4201210025

Санхүүгийн хяналт, аудитын албаны даргын
... дугаар ... он ... сарын ... өдрийн
... тушаалын хавсралт

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБАНД ХЭРЭГЛЭГДЭХ ХЭВЛЭМЭЛ
ХУУДАСНЫ НЭР ТӨРӨЛ, ТЭДГЭЭРИЙН ИНДЕКС

№	Хэвлэмэл хуудасны нэр төрөл	Хэвлэмэл хуудасны индекс	Хариуцах албан тушаалтан
1	Санхүүгийн хяналт, аудитын албаны даргын тушаал	1	Архив, бичиг хэргийн ажилтан
2	Санхүүгийн хяналт, аудитын албаны албан бичиг А4	2	Архив, бичиг хэргийн ажилтан
3	Санхүүгийн хяналт, аудитын албаны албан бичиг А5	3	Архив, бичиг хэргийн ажилтан
4	Санхүүгийн хяналт, шалгалтын улсын ахлах байцаагчийн албан шаардлага	4	Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч
5	Санхүүгийн хяналт, шалгалтын улсын ахлах байцаагчийн акт	5	Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч
6	Хяналт шалгалтын танилцуулга	6	Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч, дотоод аудитор

Жагсаалт гаргасан:

/Э.Цэлмэгбаяр/